



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Цэцэг сумын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** ХОА-2026/069/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 99047408 Цахим хаяг: boldbaatarkh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 99013699 Цахим хаяг: tsetsegsurena@audit.gov.mn Ахлах аудитор: Д.Мөнхтулга Утас: 99031809 Цахим хаяг: munkhtulgad@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.02.25 № 157

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

ЦЭЦЭГ СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Б.МЯГМАРСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цэцэг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр “Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл” хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн, 14 дүгээр зүйлийн 14.4, 14.4.5, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэн зөв байх, нийцсэн бөгөөд зохистой байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- Өмнөх онуудад үүссэн 17,292.8 мянган төгрөгийн багш ажиллагсадтай холбоотой авлагыг барагдуулаагүй,
- Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолыг зөрчин 11,601.2 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг илүү олгосон,
- Нийгмийн даатгал, татварын тайланд албан хаагчдын цалин хөлсийг 141,834.4 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлснээс өглөгийн тооцоо үүссэн ч өр төлбөрт бүртгээгүй,
- Ахлах дунд ангийн хүүхдүүдэд хоол олгосон 71,949.4 мянган төгрөгийн орлогыг төрийн сангийн дансаар дамжуулаагүй, нягтлан бодох бүртгэлд тусгаагүй,
- Дотуур байрны хүүхдийн хоол, үдийн хоолны зардлаас 20,461.2 мянган төгрөгийг ахлах, дунд ангийн хүүхдийн хоол хүнсэнд зарцуулсан,

8426050357

## **Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд 677 хүүхэд суралцаж байгаа нь хамрах тойргийн хүүхдийг 100 хувь хамруулсан байна.

## **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Тайлант онд цалин хөлсний зардалд 1,877,939.6 мянган төгрөгийг зарцуулсан нь өнгөрсөн оны гүйцэтгэлээс 21.2 хувиар, үдийн хоолны зардалд 112,611.0 мянга, тогтмол зардалд 346,791.3 мянган төгрөгийг зарцуулсан нь 2024 оны гүйцэтгэлтэй харьцуулахад 40 хувиар тус тус өссөн нь төрийн албан хаагчийн цалин, хүүхдийн хоолны зардлын норматив, цахилгаан, халаалтын үнэ тариф өссөнтэй холбоотой байна.

## **Бусад асуудлын хэсэг**

Тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөг 7 зорилтын хүрээнд 45 арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийг эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн биелэлт 89 хувьтай үнэлэгдсэн байна.

2025 онд хийсэн багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр I түвшинд 3 багш, II түвшинд 1 багш, III түвшинд 3 багш, IV түвшинд 8 багш үнэлэгдсэн байна.

## **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

## **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Х.БОЛДБААТАР



**Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл**

**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

(төгрөгөөр)

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>190,134,865.01</b>	<b>314,961,452.06</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	78,007,271.79	214,518,077.18
<b>311</b>	<b>Кассанд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	00.00
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	78,007,271.79	214,518,077.18
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	78,007,271.79	214,518,077.18
31211	Төрийн сангийн харилцах	78,007,271.79	214,518,077.18
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	31,167,184.12	20,517,755.50
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	17,779,284.12	17,292,755.50
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	13,387,900.00	3,225,000.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	13,387,900.00	3,225,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	80,960,409.10	79,925,619.38
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	18,065,700.00	24,496,300.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	19,702,800.00	27,107,710.28
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	43,191,909.10	28,321,609.10
35420	Аж ахуйн материал	942,600.00	599,000.00
35470	Бусад хангамжийн материал	27,332,609.10	27,722,609.10
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,788,709,714.36</b>	<b>1,998,028,878.86</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1,788,709,714.36	1,998,028,878.86
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1,741,061,714.36	1,950,380,878.86
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,868,311,784.00	2,249,837,964.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-619,019,832.80	-725,163,273.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,736,434.00	29,736,434.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-29,736,434.00	-29,736,434.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	554,530,548.00	600,900,851.20
39206	Хуримтлагдсан элэгдэл	-234,993,104.20	-331,261,372.38
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	222,096,473.70	226,896,473.70
39208	Хуримтлагдсан элэгдэл	-89,073,332.90	-112,780,793.18
39214	Бусад үндсэн хөрөнгө	100,000.00	100,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-100,000.00	-100,000.00
39217	Ном	39,209,178.56	41,951,028.96
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	47,648,000.00	47,648,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	47,648,000.00	47,648,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,978,844,579.37</b>	<b>2,312,990,330.92</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>2,259,011.41</b>	<b>41,154,574.60</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	2,259,011.41	41,154,574.60
<b>413</b>	<b>Өглөг</b>	2,259,011.41	41,154,574.60
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	259,011.41	6,029,561.12
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	2,000,000.00	35,125,013.48
41361	Байгууллагад төлөх өглөг	2,000,000.00	35,022,513.48
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	00.00	102,500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,976,585,567.96</b>	<b>2,271,835,756.32</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1,976,585,567.96	2,271,835,756.32
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	675,655,846.74	675,655,846.74
51101	Өмч: - төрийн	675,655,846.74	675,655,846.74
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	368,873,683.71	664,123,872.07
51210	Өмнөх үеийн үр дүн	368,873,683.71	368,873,683.71
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	295,250,188.36
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	932,056,037.51	932,056,037.51
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,978,844,579.37</b>	<b>2,312,990,330.92</b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан** (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,672,671,135.50</b>	<b>3,359,529,680.40</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>623,049,335.50</b>	<b>754,765,480.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	282,324,235.50	401,472,680.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	282,324,235.50	401,472,680.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,074,800.00	2,639,800.00
1200044	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	00.00	800,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	278,249,435.50	398,032,880.40
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	340,725,100.00	353,292,800.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	340,725,100.00	353,292,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,049,621,800.00</b>	<b>2,558,864,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,049,621,800.00	2,558,864,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,025,357,800.00	2,555,854,200.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	24,264,000.00	3,010,000.00
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	00.00	45,900,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,517,800,864.02</b>	<b>3,064,279,492.04</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,517,800,864.02</b>	<b>3,064,279,492.04</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,397,909,173.07	3,062,577,957.29
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,546,745,028.64	1,901,842,803.64
210101	Үндсэн цалин	1,537,116,628.64	1,095,481,336.11
210102	Нэмэгдэл	00.00	676,967,177.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	41,977,600.00
210104	Урамшуулал	9,628,400.00	87,416,690.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	189,144,936.96	236,262,176.24
210201	Тэтгэврийн даатгал	189,144,936.96	167,409,023.93
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	17,627,090.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	9,466,830.98
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	8,351,846.18
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	33,407,384.40
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	330,085,460.05	346,121,265.25
210301	Гэрэл, цахилгаан	10,739,660.05	19,313,865.25
210302	Түлш, халаалт	319,345,800.00	326,807,400.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,980,240.00	76,744,000.00
210401	Бичиг хэрэг	00.00	15,228,200.00
210402	Тээвэр, шатахуун	8,443,650.00	8,213,250.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	00.00	9,266,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	00.00	25,136,450.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	00.00	18,899,600.00
210408	Бараа материал акталсны зардал	536,590.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	53,875,800.00	231,521,950.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	2,383,400.00	824,350.00
210502	Хоол, хүнс	51,492,400.00	229,311,600.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,386,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	24,272,528.13	16,402,133.38
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,086,400.00	2,639,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	19,186,128.13	13,762,333.38
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	244,805,179.29	253,683,628.78
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	79,776,098.29	26,509,459.68
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	360,000.00	1,055,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	164,669,081.00	226,119,169.10
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	119,891,690.95	1,701,534.75
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	119,879,690.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	101,431,590.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	18,448,100.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	12,000.95	1,701,534.75
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,000.95	1,701,534.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>154,870,271.48</b>	<b>295,250,188.36</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>154,870,271.48</b>	<b>295,250,188.36</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан (төгрөгөөр)

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,655,846.74	932,056,037.51	368,873,683.71	1,976,585,567.96
C08	2024 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	675,655,846.74	932,056,037.51	368,873,683.71	1,976,585,567.96
D01	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,655,846.74	932,056,037.51	368,873,683.71	1,976,585,567.96
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	675,655,846.74	932,056,037.51	368,873,683.71	1,976,585,567.96
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	295,250,188.36	295,250,188.36
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	675,655,846.74	932,056,037.51	664,123,872.07	2,271,835,756.32

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан (төгрөгөөр)

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,394,421,700.00</b>	<b>2,960,696,800.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>344,799,900.00</b>	<b>2,960,696,800.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	4,074,800.00	358,942,600.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,074,800.00	5,649,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,074,800.00	2,639,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,010,000.00
<b>123</b>	<b>Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг</b>	340,725,100.00	353,292,800.00
123004	Улсын төсвөөс орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх шилжүүлэг	340,725,100.00	353,292,800.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,049,621,800.00</b>	<b>2,601,754,200.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	2,049,621,800.00	2,555,854,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,025,357,800.00	2,555,854,200.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	24,264,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	00.00	45,900,000.00
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	00.00	45,900,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>2,423,774,835.36</b>	<b>2,824,185,894.61</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,423,774,835.36</b>	<b>2,824,185,894.61</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>2,321,472,144.41</b>	<b>2,709,873,459.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,549,707,102.94	1,877,939,653.86
210101	Үндсэн цалин	923,781,540.89	1,023,036,311.77
210102	Нэмэгдэл	540,179,987.13	732,175,959.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	41,659,715.77
210104	Урамшуулал	85,745,574.92	81,067,666.49
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	197,226,900.00	252,584,247.69
210201	Тэтгэврийн даатгал	134,114,400.00	169,382,247.69
210202	Тэтгэмжийн даатгал	15,778,200.00	20,800,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,889,000.00	10,400,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	7,889,000.00	10,400,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	31,556,300.00	41,601,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	331,368,260.05	346,791,265.25
210301	Гэрэл, цахилгаан	10,844,660.05	19,983,865.25

210302	Түлш, халаалт	319,345,800.00	326,246,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,177,800.00	561,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>53,203,600.00</b>	<b>63,857,000.00</b>
210502	Хоол, хүнс	53,203,600.00	63,857,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,344,839.00</b>	<b>4,800,000.00</b>
210604	Урсгал засвар		4,800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>0.00</b>	<b>36,240,699.38</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		2,639,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		33,600,899.38
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>0.00</b>	<b>127,660,593.68</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал		115,662,605.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		11,997,988.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>0.00</b>	<b>114,312,434.75</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>112,611,000.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		112,611,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>0.00</b>	<b>1,701,434.75</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		1,701,434.75
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>(29,353,135.36)</u></b>	<b><u>136,510,905.39</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(29,353,135.36)</b>	<b>136,510,905.39</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>107,360,407.15</b>	<b>78,007,271.79</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>78,007,271.79</b>	<b>214,518,077.18</b>

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(төгрөгөөр)

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,136,529,300.00</b>	<b>2,822,484,459.86</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>3,136,529,300.00</b>	<b>2,822,484,459.86</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>3,021,894,800.00</b>	<b>2,709,873,459.86</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>2,101,002,900.00</b>	<b>1,877,939,653.86</b>
210101	Үндсэн цалин	1,266,177,100.00	1,023,036,311.77
210102	Нэмэгдэл	776,646,900.00	732,175,959.83
210103	Унаа хоолны хөнгөлөлт		41,659,715.77
210104	Урамшуулал	58,178,900.00	81,067,666.49
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>262,625,300.00</b>	<b>252,584,247.69</b>
210201	Тэтгэврийн даатгал	178,585,200.00	169,382,247.69
210202	Тэтгэмжийн даатгал	21,010,100.00	20,800,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,505,000.00	10,400,100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	10,505,000.00	10,400,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	42,020,000.00	41,601,300.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>348,492,800.00</b>	<b>346,791,265.25</b>
210301	Гэрэл, цахилгаан	20,626,400.00	19,983,865.25
210302	Түлш, халаалт	326,246,400.00	326,246,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,620,000.00	561,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>63,888,400.00</b>	<b>63,857,000.00</b>
210502	Хоол, хүнс	63,888,400.00	63,857,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,800,000.00</b>	<b>4,800,000.00</b>
210604	Урсгал засвар	4,800,000.00	4,800,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>37,271,500.00</b>	<b>36,240,699.38</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,933,500.00	2,639,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	34,338,000.00	33,600,899.38
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>203,813,900.00</b>	<b>127,660,593.68</b>

210901	Бараа үйлчилгээний бусад зардал	191,806,700.00	115,662,605.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,007,200.00	11,997,988.68
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	114,634,500.00	112,611,000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	114,634,500.00	112,611,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	114,634,500.00	112,611,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	3,136,529,300.00	2,958,995,265.25
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	2,581,444,800.00	2,555,854,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,581,444,800.00	2,555,854,200.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	353,292,800.00	351,591,265.25
132001	Орон нутгийн төсвөөс	353,292,800.00	351,591,265.25
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	201,791,700.00	51,549,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,639,800.00	2,639,800.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	121,160,000.00	48,910,000.00
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	77,991,900.00	
<b>4</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		78,007,271.79
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		214,518,077.18

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(төгрөгөөр)

Нэмэлт санхүүжилтийн гүйлгээ гараагүй болно

### Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар 530,204.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс 267,065.3 мянган төгрөгийн бүртгэл, тайлагналын алдаа<sup>1</sup>-г залруулж, баталгаажуулав. Үүнд:

- Үнэ төлбөргүй ирсэн үндсэн хөрөнгийг 267,065.3 мянган төгрөгөөр үр дүнгийн тайланд дутуу илэрхийлсэн.

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д “аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий тайлбар хүргүүлэх” заалтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Залруулагдаагүй нийт 263,139.0 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 263,139.0 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 32,062.4 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 231,076.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

### 3.1 Төлбөрийн акт

3.1.1 Илрүүлэлт: Гүйцэтгэлийн үнэлгээгээр V дугаар түвшинд үнэлэгдсэн багш нарт үр дүнгийн урамшуулалд 11,601.2 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4-д “улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал олгох”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

15.1-д “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно” 15.1.3-д “Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох”, Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 25 дугаар тогтоолын хавсралтын 3.5-д “Боловсролын ерөнхий хуулийн 26.1.2-т заасан багшийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх, дүгнэх журмын дагуу төрийн болон орон нутгийн өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багшийн ажлын үнэлгээний үр дүнд үндэслэн олгох урамшууллыг албан тушаалын сарын үндсэн цалингаас доор дурдсан хувь хэмжээгээр тооцож, улирал тутам олгоно. I түвшин 40%, II түвшин 25%, III түвшин 20%, IV түвшин 15%” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон үр дүнгийн урамшууллыг суутган авч төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

3.1.2 Илрүүлэлт: Дотуур байрны хүүхдийн хоол болон үдийн цай хөтөлбөрийн зардлаас 20,461.2 мянган төгрөгийг дунд, ахлах ангийн хүүхдүүдийн хоол хүнсэнд зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дунд, ахлах ангийн хүүхдүүдэд олгосон хоолны зардлыг төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 3.2.1 Цалингийн бүртгэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Нийгмийн даатгалын тайланг 7, 8 дугаар саруудад 22,904.9 мянган төгрөгөөр илүү, 3 дугаар улирлын татварын тайланг 118,929.5 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2-т "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Татвар, Нийгмийн даатгалын газруудтай тооцоо нийлж тайланд холбогдох засварыг хийж үлдэгдлийг баталгаажуулах.

#### 3.2.2 Хүүхдийн хоолны орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Ахлах, дунд ангийн 38,373 хүүхдүүдэд хоол өгсөн ч хоолны орлогын 75 хувь болох 71,949.4 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлээгүй, худалдан авсан бараа материалыг нягтлан бодох бүртгэлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.5-д "бүх орлого" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Ахлах дунд ангийн хүүхдүүдэд олгосон хоолны тооцоог сар бүр хийж орлогыг төрийн сангийн дансаар дамжуулан зарцуулалтад тавих хяналтыг сайжруулан ажиллах

#### 3.2.3 Авлага данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Ажиллагсадтай холбоотой өмнөх онуудад үүссэн 17,292.8 мянган төгрөгийн авлагыг тайлант онд барагдуулах ажлыг зохион байгуулаагүй Төсвийн тухай хуулийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж

авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтуудтай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажиллагсадтай холбоотой үүссэн авлагыг барагдуулах ажлыг зохион байгуулж төсвийн хөрөнгийн үр өгөөжийг дээшлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**Дөрөв. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл:**

**4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13
Цэцэг сумын сургууль	Үнэ төлбөргүй хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй	1	267,065.3	1	267,065.3			1	267,065.3				
<b>Нийт дүн</b>		<b>1</b>	<b>267,065.3</b>	<b>1</b>	<b>267,065.3</b>			<b>1</b>	<b>267,065.3</b>				

**4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Цэцэг сумын сургууль	Дотуур байр, үдийн хоолны зардлаас дунд, ахлах ангийн хүүхдүүдийн хоолны зардлыг санхүүжүүлсэн.	1	20,461.2	1	20,461.2						
	Үр дүнгийн урамшуулал илүү олгосон	1	11,601.2	1	11,601.2						
	Нийгмийн даатгал, татварын тайланг зөрүүтэй тайлагнасан.	1	141,834.4					1	141,834.4		

Ховд аймгийн Цэцэг сумын сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Ажилчдаас авах авлагыг барагдуулаагүй	1	17,292.8					1	17,292.8		
Ахлах, дунд ангийн хүүхдийн хоолны орлогыг төрийн сангийн дансаар дамжуулаагүй	1	71,949.4					1	71,949.4		
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>263,139.0</b>	<b>2</b>	<b>32,062.4</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>231,076.6</b>		

**Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		